



БАРИЛГЫН САЛБАРЫН 2021 – 2022 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамтын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжинд нийцэж байгаа тул

2021 оны 03.... дугаар сарын 10...ны өдөр бүртгэв.

УЛААНБААТАР ХОТ

2021 оны 02.. дугаар сарын 10..ны өдөр

БАРИЛГЫН САЛБАРЫН 2021-2022 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Нэг. Нийтлэг зүйл

Энэхүү хэлэлцээрийг Хөдөлмөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь заалт, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 24 дүгээр тушаал, “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01/21 дүгээр тушаал, “Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо” ТББ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан төлөөлөгчид /тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх/ салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, норм ба дүрэм, стандарт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, жендэрийн эрх тэгш байдал, зохистой хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах зорилгоор 2021 оны дугаар сарын-ны өдөр байгуулав.

Талууд дараах үйл ажиллагаа, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх, зохион байгуулах, тодорхой үр дүнтэй ажиллах зөвшилцэлд хүрч, саналаа илэрхийлэв.

Хоёр. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 70 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд болон Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогод тусгагдсан холбогдох ажлуудыг хамтран хэрэгжүүлнэ.


2.2. “Барилга байгууламжийн чанарын улсын зөвлөгөөн-2020”-ний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан барилга, хот байгуулалтын салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, норм ба стандартуудыг шинэчлэн боловсруулах болон бусад ажлуудыг хэрэгжүүлэхэд салбарын төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоод, ТББ, аж ахуйн нэгжүүдийн оролцоог хангаж ажиллана.

2.3. “Барилгын салбарын норм нормативын сан”-ийн хөрөнгийн зарцуулалтыг ил тод болгох, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагуудын оролцоог хангах, барилгын салбарт норм ба дүрэм, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, шинэчлэн боловсруулах зэрэг үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох чиглэлд хамтран ажиллана.

Гурав. Төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар

3.1. Засгийн газрын “150 мянган айлын-Орон сууц” үндэсний хөтөлбөр, “Орлогод нийцсэн орон сууц”, “Түрээсийн орон сууц”, “Залуус -1, 2 орон сууцны хороолол” зэрэг төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг хангаж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг гадаад, дотоодоос бүрдүүлэн хэрэгжүүлнэ.

3.2. Засгийн газрын “150 мянган айлын-Орон сууц” үндэсний хөтөлбөр, “Орлогод нийцсэн орон сууц”, “Түрээсийн орон сууц”, “Залуус -1, 2 орон



сууцны хороолол” зэрэг төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагууд, мэргэжилтэй ажилчдын оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг нь дээшлүүлэх зэрэг арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөдөлмөр эрхлэлтийн талаар

4.1. Салбарын инженер техникийн болон мэргэжилтэй ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн судалгааг гарган мэдээллийн санг бүрдүүлэх, эрэлтэд суурilan захиалгаар мэргэжилтнээ бэлтгүүлэх тогтолцоог бий болгох, эрэлт ихтэй ажил мэргэжлийг богино хугацаанд бэлтгэх ажлыг боловсрол, сургалтын болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч зохион байгуулна.

4.2. Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-д "Барилгын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, ажилтан бүртгэл, мэдээллийн санд хамрагдана." гэж заасны дагуу ТББ, аж ахуйн нэгжүүд өөрийн байгууллагын болон гэрээт ажилтнуудаа нэгдсэн цахим бүртгэлд тогтмол, бүрэн хамруулна.

4.3. Барилгын салбарын ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлт /YAMAT/, салбарын боловсролын нэр, индексэд нэмэлт өөрчлөлт оруулан төслийг боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар хамтран батлуулна. Үүний үндсэн дээр мэргэжлийн стандарт лавлахуудыг боловсруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хийнэ.

4.4. Барилга, барилгын материал, хийцийн үйлдвэрлэлийн инженер, техникийн ажилтнууд болон ажиллагчдын тэтгэвэрийг хөнгөлттэй нөхцлөөр тогтоолгохоор Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Тэтгэврийг хөнгөлттэй тогтоо газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулна.


4.5. Барилгын салбарын хөдөлмөрийн норм нормативыг шинэчлэх, ажилтнуудыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах чиглэлд холбогдох арга хэмжээг авч, дэмжлэг үзүүлнэ.

4.6. Барилгын гүйцэтгэгч байгууллагууд Барилгын тухай хуулийн 40.1.9-д заасны дагуу барилга байгууламжийн суурь, хана, хучилт, шат, араг бүтээц, дээврийн болон бусад ажлуудыг өөрийн ажилтнаар эсхүл хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажилтнуудаар гүйцэтгүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомжийг мөрдүүлэх чиглэлд үзлэг, шалгалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран явуулна.

Тав. Цалин хөлсний талаар

5.1. Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн дагуу барилгын салбарын ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 648,480 /зургаан зуун дөчин найман мянга дөрвөн зуун наян/ төгрөгөөс багагүй байлгах талаар холбогдох арга хэмжээг зохион байгуулна.

5.2. Барилгын салбарын ажилтнуудын хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн байдалд Талууд хамтарсан үзлэг хийж, зөрчил гарсан тохиолдолд арилгуулах болон бусад арга хэмжээг авч ажиллана.



5.3. Монгол Улсад өргөн хэрэглээний бараа материал, бензин шатахууны үнийн өсөлт, долларын ханш нэмэгдсэнтэй холбогдуулан Барилгын материал, хийцийн үйлдвэрлэлийн ажилтнуудын “Тарифт цалингийн жишиг—ийг шинэчлэн батлуулах ажлыг хамтран зохион байгуулна.

Зургаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар

6.1. Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1988 оны 167 дугаар конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан Монголын барилгын салбарын ХАБЭА-н хууль, дүрэм журмыг уг конвенцид нийцүүлэн боловсронгуй болгох, нэвтрүүлэх ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

6.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны үйл ажиллагаатай Барилгын салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны үйл ажиллагааг уялдуулан эрчимжүүлнэ.

6.3. “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ыг хэрэгжүүлэхээр Барилга, хот байгуулалтын сайдын албан даалгавар гарган барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн компаниудад хүргүүлж, хэрэгжүүлэх чиглэлд талууд хамтран ажиллана.

6.4. “Барилгын салбарын мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн ур чадварыг нь үнэлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах зэрэг замаар бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх асуудлыг Барилга, хот байгуулалтын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамаар дэмжүүлэн хэрэгжүүлнэ.

6.5. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА-аас хэрэгжүүлж буй “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд байгуулсан ХАБЭА-н туршилт, сургалтын танхимыг ХАБЭА-н сургалтанд ашиглаж барилгын салбарын инженер, техникийн ажилтнууд болон мэргэжилтэй ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад тогтмол хамруулж байх арга хэмжээг авна.

6.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын нэгдсэн өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулна.

6.7. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичиг болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудын барилга байгууламжийн угсралтын ажлын явц дахь хэрэгжилтэд үзлэг хийж, мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

6.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний 5 дахь хөтөлбөрийн зорилтын хүрээнд барилгын салбарын ХАБЭА-н цахим сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож, сургалт зохион байгуулах ажлыг ГОУХАН \GIZ\ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

6.9. 2021-2022 оныг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны соёлыг ажлын байранд хэвшигүүлэн, инженер техникийн болон бусад ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх” жил болгон холбогдох ажлыг зохион байгуулна.

6.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг хангаж ажилласан барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан алдаршуулж, Барилгачдын талбайд тугийг залах ажлыг зохион байгуулна.

Долоо. Салбарын мэдээллийн цахимжуулалт, жендэрийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар

7.1. Салбарын инженер техникийн болон бусад богино хугацааны сургалт, бүртгэлийн цахим платформыг хөгжүүлж, нэвтрүүлнэ.

7.2. Жендерийн үндэсний хорооноос гаргасан “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх талаар гаргасан бодлогын зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын албан хаагчдын дунд санал асуулга явуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, ажлын ачаалал, хөдөлмөрийн цаг, нормыг баримтлан хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулж, хэвшүүлнэ.

7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах, барилга байгууламжийн зураг төсөлд холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусган хэрэгжүүлж байх, хуучин барилгын орц, гарц болон бусад дэд бүтцийг ХБИ-ийн эрх ашиг, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах ажлыг зохион байгуулна.

Найм. Нийгмийн түншлэлийн талаар

8.1. Барилгын салбарын мэргэжлийн холбоод төрийн бус байгууллагуудын хамтын түншлэлийн үйл ажиллагаа болон төрийн зарим чиг үүргүүдийг гэрээний үндсэн дээр хариуцлагатай гүйцэтгэх зэрэг хамтын ажиллагааг дэмжинэ.

8.2. Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцоог хангаж ажиллана.


8.3. Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад эрх зүйн зохицуулалт, зарчмыг мөрдлөг болгох, итгэлцэл, ойлголцол, хүндлэл, хүнлэг харилцааны соёл, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэн, байгууллагынхаа мэргэжилтэй ажиллах хүч, техник, технологийн чадамж, соёлыг сайжруулна.

Ес. Хэлэлцээрийг мөрдөж, хэрэгжүүлэх чиглэлээр

9.1. Энэхүү хэлэлцээр нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс хүчин төгөлдөр болно.

9.2. Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө шинэ хэлэлцээр байгуулаагүй, эсвэл нэмэлт, өөрчлөлт оруулаагүй бол талууд энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөнө.

9.3. Хэлэлцээрийн биелэлтэд талууд хамтран хяналт тавина.



9.4. Хэлэлцээрийн үр дүнг бүтэн жилээр нэгтгэн дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороонд хүргүүлнэ.

9.5 Энэхүү хэлэлцээрийн талуудын удирдлага, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, мөн шинэчлэн зохион байгуулагдах нь хэлэлцээр дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн залгамжлагчид энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

9.6. Хэлэлцээрт талууд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримталсан журмыг дагаж мөрдөнө.

9.7. Энэхүү хэлэлцээрийг биелүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлнэ. Ажлын төлөвлөгөөг талууд өөрсдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангана.

9.8. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд үүссэн маргааныг хамтран хэлэлцэх, тохиролцох бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСАН:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:

Дэд сайд

Э.ЗОЛБОО

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Д.БАЯРСАЙХАН

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.ГАНТУЛГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга

О.ЛХАГВАЦЭДЭН

Хуулийн хэлтсийн дарга


Б.НЯМДОРЖ

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ:

“Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн
холбоо” ТББ-ын нарийн бичгийн дарга

Ц.ЭНХЦЭЦЭГ

“Нэгдмэл үйлдвэрчний эвлэлүүдийн



холбоо” ТББ-ын дарга

S. Amk
Я.АЛТАНТУЯА

“Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн
холбоо” ТББ-ын тэргүүлэгч гишүүн

D. Amgalanbayar
Д.АМГАЛАНБАЯР

“Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн
холбоо” ТББ-ын тэргүүлэгч гишүүн

S.
Б.ЦЭРЭНДУЛАМ

“Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн
холбоо” ТББ-ын тэргүүлэгч гишүүн

S. Amk
С.ДЭМЧИГ

АЖИЛ ОЛГОГЧДЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Монголын барилгын гүйцэтгэгч байгууллагуудын
холбоо” ТББ-ын ерөнхийлөгч

S. Amk
Б.ЖҮГДЭР

“Цахилгаан автоматик мэдээлэл, холбоо
дохиоллын инженерүүдийн холбоо”
ТББ-ын тэргүүн

S. Amk
А.БЯМБАСҮРЭН

“Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн
холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал

S. Amk
О.ЛХАГВАДОРЖ

“Монголын барилгын зураг төсөл зохиогчдын
холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал

S. Amk
Д.ЦЭВЭЛМАА

“Монголын цахилгаан, сантехник угсралтын
мэргэжлийн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал

S. Amk
О.ЗАНДАНХҮҮ

